



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
САНДАГИЙН БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвбаатарын МӨНХТУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-18, Факс: 32-70-16
E-mail: munkhtulga@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.05.24 № УИР-03/6075
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт хуудас.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



П.МӨНХТУЛГА

000048



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвбаатарын МӨНХТУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-18, Факс: 32-70-16
E-mail: munkhtulga@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.04.20 № УИХ-03/4187
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл болон холбогдох судалгааг хавсаргав.

Хавсралт 45 хуудас.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



П.МӨНХТУЛГА

000045



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.МӨНХТУЛГА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.02.16 № НЭТ / 529
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт
авахаар ирүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг
Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

700265002503

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын санаачлан боловсруулсан Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын санаачлан боловсруулсан Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төсөлд тэтгэврийн зээлийн хүүг Засгийн газар тусгай журам батлан тогтоохоор заасан нь Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан “банк зээлийн хүүг өөрөө тогтоох” эрх, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан банкны үйл ажиллагаанд төрийн байгууллага оролцохгүй байх, мөн зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан банк төрийн үүргийг хариуцахгүй байх үндсэн зарчимд нийцэхгүй байна;

2.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт тус тус банкны зээлийн үйл ажиллагаатай холбоотой журам батлах, шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг Монголбанканд олгосон.

Харин Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон зээлийн үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан дээрх хуулиар Засгийн газарт банкны зээлийн үйл ажиллагаатай шууд холбоотой шийдвэр гаргах, хяналт тавих тодорхой бүрэн эрх олгогдоогүй байна. Иймд хуулийн төсөлд тусгасан тэтгэврийн зээлийн хүүг тогтоох журмыг батлах эрхийг Засгийн газарт олгох зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹1.5 дахь заалтад заасан “захиргааны хэм хэмжээний акт батлах этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх” шаардлагыг хангахгүй байна. Өөрөөр хэлбэл, банкнаас иргэнд зээл олгоход баримтлах хүүгийн хэмжээ, журмыг тогтоох нь Засгийн газрын үндсэн чиг үүрэгт хамаарахгүй;

3.Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлд тус тус зааснаар Монголбанканд төрийн мөнгөний бодлогыг боловсруулах болон бодлогын хүү зэрэг санхүүгийн хэрэгслээр дамжуулан хүүгийн нэгдсэн бодлогыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. Мөн тус хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 3, 6 дахь хэсэгт Монголбанк Засгийн газраас хараат бусаар үйл ажиллагаа явуулах зарчмыг хуульчилсан. Иймд Засгийн газраас тэтгэврийн зээлийн хүүг тогтоох нь Монголбанкны санхүүгийн хэрэгслээр дамжуулан мөнгөний бодлогыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах эрсдэлтэй бөгөөд Монголбанкны хараат бус байдлын зарчимд нийцэхгүй байна;

4.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалтад заасны дагуу зээлийн хүү нь зээлийн гэрээний үндсэн дээр банкнаас харилцагчтай харилцан тохиролцох мөнгөн хөрөнгийг ашигласны хариу төлбөр юм. Энэ хүрээнд Засгийн газраас тэтгэврийн зээлийн хүүг журам батлан тогтоох нь Иргэний хуулиар баталгаажуулсан гэрээний эрх чөлөөний зарчимд нийцэхгүй байна;

5.Зээлийн хүү нь мөнгөний бодлогын хэрэгжилтийг дамжуулах чухал суваг тул гүйцэтгэх засаглалаас шууд тогтоох нь мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдлын зорилготой зөрчилдөх эрсдэлтэй. Олон улсын туршлагаас үзэхэд, ийм зохицуулалтын үед зээлийн хүү буурах боловч үйлчилгээний шимтгэл, нэмэлт төлбөрийг өсгөх, зээлийн бодит өртгийг ил тод бус болгох, улмаар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгод харшлах эрсдэлтэй байдаг.

Тэтгэврийн орлого барьцаалсан зээлийн хүүг бууруулах нь богино хугацаанд ахмад настны өрийн дарамтыг багасгах ач холбогдолтой мэт боловч Засгийн газраас тэтгэврийн зээлийн хүүг тогтоох нь зээлийн эрсдэлийн бодит үнэлгээг алдагдуулах, зээлийн нийлүүлэлтийг хумих, банкны салбарын бие даасан байдал, санхүүгийн сахилга батад сөргөөр нөлөөлөх, улмаар ахмад настны амьжиргааны баталгаа алдагдах, ядууралд өртөх эрсдэлийг нэмэгдүүлнэ.

Түүнчлэн, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлогын чиглэлтэй нийцэхгүй байна;

6.Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад Засгийн газраас тэтгэврийн зээлийн хүүг журмаар тогтоох аргачлал, шалгуур, хугацаа, хамрах хүрээ, эдийн засаг, санхүүгийн үндэслэлийг тодорхойлоогүй бөгөөд хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан судлахдаа хүний эрх, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг цогцоор нь үнэлээгүй байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад заасан шаардлагыг хангахгүй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилт 3.1-д “Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг өрх, иргэдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ” гэж, 3.1.18-д “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь хэсэгт зааснаар “тэтгэвэр” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүссэн даатгуулагч, хүнд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ гэж зааж өгсөн байна.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай”-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт тэтгэврийг:

- 1.Өндөр насны;
- 2.Хөдөлмөрийн чадвар алдсаны;
- 3.Тэжээгчээ алдсаны гэсэн төрлүүдтэй байхаар хуульчилсан.

Тэтгэвэр авагч иргэний орлогын эх үүсвэр нь “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль”-д заасны дагуу үүсдэг төдийгүй “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, мөн хуулийн 20 дугаар зүйл, Иргэний хуулийн 451 дүгээр зүйлд тус тус заасны дагуу зээлийн гэрээ байгуулдаг.

Тэтгэврийн зээлийн зорилго нь өндөр настай иргэдийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн байдаг төдийгүй энэ зорилгыг баталгаажуулж хууль тогтоогчийн зүгээс “Ахмад настны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ.” гэж хуульчилсан.

Иймд дээрх хууль эрх зүйн баримт бичигт тусгасан зорилго, зорилт нь хуулийн төслийг боловсруулах үндэслэл болж байна.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Манай улс анх 2010 онд Банкны тухай хууль, 2023 онд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай хууль”-ийг тус тус баталж хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын сан 2024 онд 5.6 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлснээс давхардсан тоогоор 761.9 мянган хүний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт 5.1 их наяд төгрөг зарцуулсан байна.

Тэтгэврийн тогтолцоо нь санхүүгийн хувьд тогтвортой бөгөөд хүртээмжтэй байх тэнцвэрийг хадгалахын зэрэгцээ ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой байх шаардлагыг хангасан байх ёстой.

Манай улсын 60 ба түүнээс дээш насны ахмад настны тоо 2010 байдлаар 5.8 хувь, 2021 оны байдлаар 7.9 хувь, 2024 онд 9.3 хувь байгаа бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох тооцоолол байна. Хүн амын дундаж наслалт (0 наснаас тооцоолсон) 2024 онд 71.7 жил болж 2000 оны дундаж наслалттай харьцуулахад 8.6 жилээр өссөн. Харин эрэгтэйчүүдийн дундаж наслалт мөн онтой харьцуулахад 7.5 жилээр нэмэгдэж 67.9 жил, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 11.0 жилээр нэмэгдэж 77.1 жил болж жилээс жилд өсөх хандлагатай байна.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар Монгол Улсад нийгмийн даатгалын сангаас болон цэргийн тэтгэвэр авагч 2024 онд 531.8 мянга байсан бол 2030 онд 605.0 мянга, 2040 онд 728.0 мянга, 2050 онд 1,100.0 мянгад хүрэхээр байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Монгол Улсын хүн амын хэтийн тооцооллыг 2024 оны байдлаар эмэгтэй хүн 55 наснаас хойш 25 жил, эрэгтэй хүн 60 наснаас хойш 16 жил амьдарч байна гэж тооцсон. Ирээдүйд буюу 2050 онд уг хугацаа эмэгтэй хүний хувьд 28.4 жил, эрэгтэй хүний хувьд 19.6 жил болж өсөхөөр байна.

Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангаас 2024 онд 4.4 их наяд төгрөгийг 509.1 мянган тэтгэвэр авагч (үүнээс 81 хувь буюу 414.3 мянга нь өндөр насны тэтгэвэр авагч)-ийн тэтгэвэрт зарцуулсан.

Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд 2022 онд 840 тэрбум төгрөг, 2023 онд 760 тэрбум, 2024 онд 1.2 их наяд төгрөг олгосон бол 2025 онд 1.45 их наяд төгрөг олгоно. Цаашид 2030 онд 3.7, 2035 онд 5.7 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. (Үүнд 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн албан хаагчдын тэтгэврийн зардлыг багтсан болно.)

Тэтгэвэр авагчдын 45 орчим хувь нь бүрэн тэтгэврийн доод хэмжээ, 16 орчим хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ авч байна. Тэтгэврийн доод хэмжээг тэтгэврийн хэмжээтэй зэрэгцүүлэн удаа дараа нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж зааж өгсөнтэй нийцэж байгаа болно.

Тэтгэвэр авагч иргэд нь амьдралын хэрэгцээ шаардлагаар банкны үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдүүдээс тэтгэвэр барьцаалсан зээл авч байгаа болно. Уг тэтгэвэр барьцаалсан зээлийн хүү нь өндөр байгаагаас шалтгаалхан

тухайн төрлийн харилцаанд оролцогч иргэд нь зээл, зээлийн хүүгийн дарамтад орох нөхцөл байдал үүсч байна. Энэ нь тэтгэвэр авагч иргэдийн орлогын эх үүсвэрт нөлөөлөх нөхцөл бий болгож байгаа тул Банкны тухай хуульд нэмэлт оруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5-д заасны дагуу хуульд нэмэлт оруулах хэлбэрээр боловсруулна. Хуулийн төсөл нь нэг зүйлтэй байх бөгөөд “Банк иргэнд олгох тэтгэврийн зээлийн хүүг тогтооход энэ хуулийн 10.1 дэх заалт хамаарахгүй, түүнчлэн тэтгэврийн зээлийн хүүг тогтоох журмыг Засгийн газар батлах” зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.Ахмад настны тэтгэврийн зээлийн хүү буурна.

2.Ахмад настны нийгмийн баталгааг хангахад чухал ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль, тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд Засгийн газарт чиглэл өгөх тухай “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

--- оОо ---

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн зааснаар манай улс иргэдийн нийгмийн баталгааг хангах үүргийг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан.

Дээрх үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай, Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиудыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь хэсэгт зааснаар “тэтгэвэр” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүссэн даатгуулагч, хүнд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ гэж зааж өгсөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар тэтгэвэрийг :

- өндөр насны;
- хөдөлмөрийн чадвар алдсаны;
- тэжээгчээ алдсаны гэсэн төрлүүдтэй байхаар хуульчилжээ.

Дээрх тэтгэвэр авагч иргэдийн орлогын эх үүсвэр нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу үүсч байгаа билээ. Нэгэнт байнгын тогтвортой орлоготой байх тул Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг, мөн хуулийн 20 дугаар зүйл, Иргэний хуулийн 451 дүгээр зүйлд тус тус заасны дагуу зээлийн гэрээ байгуулах эрх үүсэж байгаа болно. Хуулийн энэхүү зохицуулалтад зээлийн гэрээ байгуулах эрхтэй эсэх болон зээлийн гэрээний нийтлэг зохицуулалтуудыг л тусгасан байна.

Тэтгэврийн зээлийн гол зорилго нь өндөр настай иргэдийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн байдаг билээ. Энэхүү зорилгыг баталгаажуулж хууль тогтоогчийн зүгээс “Ахмад настны тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ” гэж хуульчилж өгсөн. Цаашлаад ахмад настны нийгмийн баталгааг хангахад дан ганц орлогыг нэмэгдүүлэхээс гадна зээлийн хүүг багасгах шаардлагатай.

Гэвч дээр дурдсанчлан зээлийн хүүг банк өөрөө тогтооно гэж хуульчилж өгсөн байх тул ахмад настны тэтгэврийн зээлийн хүүг багасгахын тулд Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд нэмэлт оруулах зайлшгүй шаардлагатай байна гэж үзлээ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн зааснаар манай улс иргэдийн нийгмийн баталгааг хангах үүргийг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан.

Дээрх үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэрийн тухай, Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиудыг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь хэсэгт зааснаар “тэтгэвэр” гэж нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүссэн даатгуулагч, хүнд сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ гэж зааж өгсөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар тэтгэвэрийг :

1. өндөр насны;
2. хөдөлмөрийн чадвар алдсаны;
3. тэжээгчээ алдсаны гэсэн төрлүүдтэй байхаар хуульчилжээ.

Дээрх тэтгэвэр авагч иргэдийн орлогын эх үүсвэр нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу үүсч байгаа билээ. Нэгэнт байнгын тогтвортой орлоготой байх тул Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг, мөн хуулийн 20 дугаар зүйл, Иргэний хуулийн 451 дүгээр зүйлд тус тус заасны дагуу зээлийн гэрээ байгуулах эрх үүсэж байгаа болно. Хуулийн энэхүү зохицуулалтад зээлийн гэрээ байгуулах эрхтэй эсэх болон зээлийн гэрээний нийтлэг зохицуулалтуудыг л тусгасан байна.

Тэтгэврийн зээлийн талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалтыг судалж үзэхэд:

1. Их британи Улсын эрх зүйн зохицуулалтын хувьд:

Их Британи Улсад тэтгэврийг барьцаалсан зээлийн тухай хууль байхгүй бөгөөд харин өндөр настнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг дараах хууль, журмаар зохицуулж байна. Үүнд:

- Улсын тэтгэврийн кредитийн тухай хууль /State Pension Credit Act 2002/,
- Улсын тэтгэврийн кредитийн журам /State Pension Credit Regulations 2002 (SI 2002 No. 1792)/,
- Тэтгэврийн тухай хууль /Pensions act/ гэх мэт.

Улсын тэтгэврийн кредитийн тухай хууль /State Pension Credit Act 2002/-иар өндөр настны эрүүл мэндийн үйлчилгээнд тусламж үзүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд тусламж үзүүлэх зорилгоор олгож буй санхүүгийн дэмжлэг бүхий нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулж байна.

Уг хуульд зааснаар дээрх зорилгоор олгож буй улсын нэмэлт тэтгэврийг амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, 65-аас дээш насны өндөр настнуудад улсын тэтгэвэр дээр нь нэмэлт тэтгэлэг байдлаар олгодог.

Харин хувийн тэтгэврийн хуримтлалын сангаас ирээдүйн тэтгэврээ урьдчилан зээлэх үйлчилгээ байдаг.

Өөрөөр хэлбэл тэтгэврийн насанд хүрээгүй ч гэсэн өөрийн тэтгэврийн хуримтлалаа барьцаалан урьдчилан зээл авах боломжтой байна.

3. Австрали Улсын эрх зүйн зохицуулалтын хувьд:

Австрали Улсад “Тэтгэвэр барьцаалсан зээлийн тухай” тусгайлсан хуулийн зохицуулалтгүй байна.

Банкны зээлийн тухайд ч “Тэтгэвэр барьцаалсан зээл” гэж тусгайлсан зээлийн төрөлгүй юм. Тэтгэвэр авагчид нь зээл авахыг хүссэн иргэдийн нэгэн адил хэрэглээний богино хугацааны зээлийн сонголт хийж үйлчилгээ авах эрхтэй байдаг байна. Засгийн газраас нь тэтгэврийн насны зээл хүссэн иргэдэд зориулан “Засгийн газрын тэтгэвэр авагчдад зориулсан дэмжлэг” нэртэй хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Тус хөтөлбөр нь бага орлоготой тэтгэвэр авагчдад болон бусад тэтгэврийн насны хүмүүст санхүүгийн дэмжлэг шаардлагатай үед тэдний нийгмийн асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Хөтөлбөрийн хүрээнд тэтгэвэр авагчдад дараах 2 төрлийн богино хугацааны зээлийг арилжааны банкаар дамжуулан олгодог байна. Үүнд:

- 16 хоногоос 1 жил хүртэлх хугацаагаар 100-2000 хүртэлх ам.доллар, хүүгүй зээлдүүлнэ,
- Зээл хүссэн тэтгэврийн насны бага орлоготой иргэдэд зайлшгүй шаардлагатай эмчилгээний төлбөр, өрхийн хэрэгцээний нэн шаардлагатай эд зүйл худалдан авах, автомашины засвар үйлчилгээтэй холбоотой гэх мэт зардлуудад 12-18 сарын хугацаагаар 1200 хүртэлх ам.доллар хүүгүй зээл олгоно.

Тэтгэвэр авагчдад арилжааны банкаар олгогдох хэрэглээний зээлийн нөхцөл:

Тэтгэвэр авагчдад 4-6 долоо хоногоор 2000 хүртэлх ам.доллар, зээлийн хүүг тухайн банк тодорхойлж олгоно. Тэтгэвэр авагчдад дээрх 2 төрлийн зээлээс гадна олон нийтийн сайн дурын санхүүгийн тусламжийн хөтөлбөрүүдээр дамжуулан зайлшгүй шаардлагатай өрхийн эд зүйлс худалдан авах зориулалтаар 800-3000 хүртэлх ам.долларын зээлийг бага хүүтэй олгохоос гадна өрхийн орлогыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.

2. Америкийн нэгдсэн улсын хувьд:

АНУ-д тэтгэвэр барьцаалсан зээлийн асуудал сүүлийн жилүүдэд нэлээд хурцадмал яригдаж буй асуудлын нэг болж байгаа юм. АНУ-ын нэгэн сонин сурвалжлагч, сэтгүүлч Женнифер Абелийн бичсэнээр: «Бидний амьдралд гунигтай боловч зайлсхийх аргагүй, үнэн баримттай нэгэн зүйл байна. Энэ бол «санхүүгийн хувьд хэчнээн хүнд байвч, таны энэ мэт хүнд байдлыг улам бүр муутгаж байж өөртөө ашиг олдог хүмүүс байгаа явдал юм.

Ийнхүү ашиг олдог хүмүүсийн ихэнх нь тэтгэврийн зээлийг (бастэтгэврээ урьдчилж авах ч гэж нэрлэдэг) нэлээд ашигтай бизнес гэж үздэг байна» гэжээ. Үүнээс үзэхэд АНУ-д Тэтгэвэр барьцаалсан зээлийн асуудал бизнесийн хэмжээнд хүрсэн ч тодорхой хууль эрх зүйн зохицуулалтгүй өнөөг хүрчээ.

Ийм учраас, АНУ-ын Холбооны Худалдааны Комиссоос (Federal Trade Commission) тэтгэврээ урьдчилан авах төлөвлөгөөний аюул, эрсдэлийн тухайд анхааруулан сануулгыг (consumer warning) нийтлүүлсэн байдаг байна. Мөн Форбос

сэтгүүлийн 2013 оны 4-р сарын 30-ны дугаарт Жон Уасик хэмээх нийтлэлч «Тэтгэврийн зээл бол хараахан хуулиар зохицуулагдаагүй байгаа хор мөн» хэмээх нийтлэлийг гаргажээ.

Түүний бичсэнээр бол энэхүү тэтгэврийн зээлд хамрагдагсдын ихэнх нь засгийн газрын эсхүл цэрэг армийн тэтгэвэртэй хүмүүс ба нэгэнт холбооны засгийн газрын албан хаагчид нь тэтгэврийн төлбөрөө гуравдагч этгээдэд шилжүүлэх нь хууль бус байдаг тул эдгээр компаниудын үйл ажиллагаа хууль ёсны гэдэг нь маш сэжигтэй бөгөөд тодорхойгүй хэрэг мөн гэжээ.

Мөн Холбооны Худалдааны Комиссын сануулгаас гадна Мэйне муж улсын Пайн Три Легал Ассистанс (Pine Tree Legal Assistance) хэмээх групп бүх АНУ-ын оршин суугчдад зориулж “Аюултай тэтгэврийн зээлийн таван шинж” гэдэг нийтлэл гаргасан бол Нью-Йорк Таймсийн «Тэтгэврийн зээл нь тэтгэврийн насныхныг илүү их өрөнд оруулж байна» гэх зэрэг нийтлэлүүдэд энэ талаар тодорхой бичжээ.

Улсын хэрэглэгчдийг хамгаалах агентлаг болох «Холбооны Худалдааны Комисс»-оос «Маргаашийн тэтгэврийн чекээ өнөөдөр бэлэн мөнгө болгож ав» гэсэн уриатай тэтгэврийн урьдчилгаа, тэтгэврийн худалдаа, тэтгэврийн зээл гэхчлэн янз бүрээр нэрлэгддэг тэдгээр бизнес үйлчилгээний хэрэглэгчдэд зориулан тэтгэврийн зээл нь ихэвчлэн их өндөр хүүтэй, хүү багатай байлаа ч өндөр татвар төлөхүйц нөхцөлтэй тул танд хохиролтой байдаг гэсэн сануулга, зөвлөмжийг өгсөн байдаг ажээ.

Зээл олгогчид нь ахмад дайчид эсхүл засгийн газраас тэтгэвэрт гарагсдыг гол үйлчлүүлэгчдээ болгодог нь тэднийг баталгаатай орлоготой гэж үздэг ба тэднийг банканд шинэ данс нээхийг санал болгодог. Ингэснээр тухайн дансыг зээл олгогч компани хянах боломжтой болохоор үл барам, энэ нь тэдний хувьд «Засгаас олгож буй тэтгэврийг гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй» хэмээх хуулийн заалтаас зайлсхийн хийдүүлэх арга болдог байна.

Харин Монгол Улсын хувьд Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “*Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг өөрөө тогтооно*” гэж нарийвчлан хуульчилж өгчээ. **Тэтгэврийн зээл нь мөн л адил энэхүү зохицуулалтын дагуу олгогдож байгаа болно.** Гэвч нь хуулийн энэхүү зохицуулалт нь зарим төрлийн нийгмийн харилцаанд төрөөс баримталж буй бодлогод нийцэхгүй байгаа билээ.

Учир нь тэтгэврийн зээлийн гол зорилго нь өндөр настай иргэдийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн байдаг билээ. Энэхүү зорилгыг баталгаажуулж хууль тогтоогчийн зүгээс Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т *“Ахмад настны орлогын баталгааг хангах зорилгоор тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон инфляцийн өөрчлөлтийг харгалзан Засгийн газар тухай бүр нэмэгдүүлнэ”* гэж хуульчилж өгсөн. Цаашлаад ахмад настны нийгмийн баталгааг хангахад дан ганц орлогыг нэмэгдүүлэхээс гадна зээлийн хүүг багасгах шаардлагатай.

Гэвч дээр дурдсанчлан зээлийн хүүг банк өөрөө тогтооно гэж хуульчилж өгсөн байх тул ахмад настны тэтгэврийн зээлийн хүүг багасгахын тулд Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд нэмэлт оруулах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах 10.4, 10.5 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

"10.4. Банк иргэнд олгох тэтгэврийн зээлийн хүүг тогтооход энэ хуулийн 10.1 дэх хэсэг хамаарахгүй.

10.5. Энэ хуулийн 10.4-т заасан тэтгэврийн зээлийн хүүг тогтоох журмыг Засгийн газар батална."

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Энэ хуулийг баталсантай холбогдуулан иргэнд олгох тэтгэврийн зээлийн хүүг тогтоох журмыг баталж, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-д даалгасугай.

2.Энэ тогтоолыг Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай 2026 оны дугаар сарын..... ны өдрийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг